



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 8 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 318

Улаанбаатар
хот

Төрийн өмчит хуулийн этгээд
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17.1.1, Иргэний хуулийн 31.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, засаглалыг сайжруулах зорилгоор “Эрчим хүчний хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар болон “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нийлүүлэн “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн зохион байгуулсугай.

2. “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

3. “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нийт хувьцааны 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус эзэмшүүлсүгэй.

4. “Эрчим хүчний хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нийлүүлсэнтэй холбогдуулан хаалтын балансыг гаргаж, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг зохих журмын дагуу “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлэх арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгасугай.

5. “Эрчим хүчний хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Хан-Уул дүүргийн 3 хорооны нутаг дэвсгэрт байрлалтай 16,900,998,000.0 (арван зургаан тэрбум есөн зуун сая есөн зуун ерэн найман мянган) төгрөгийн балансын үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан барилга байгууламжийг “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

6. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлалтай 1,584,648,979.0 (нэг тэрбум таван зуун наян дөрвөн сая зургаан зуун дөчин найман мянга есөн зуун далан есөн) төгрөгийн балансын үнэ бүхий 3 дугаар хавсралтад заасан барилга байгууламжийг Эрчим хүчний яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

7. Энэ тогтоолын 4, 5-д заасан үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.

8. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эрчим хүчний хөгжлийн төв байгуулах тухай” Засгийн газрын 2012 оны 51 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Н.ТАВИНБЭХ

**“ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилго нь “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн үндсэн баримт бичиг болно.

1.2.“Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани нь эрчим хүчний салбарт улсын төсвийн болон гадаад, дотоодын болон бусад хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, хөтөлбөрт захиалагчийн техникийн хяналт тавих, эрчим хүчний барилга байгууламжийг барих ажлын зураг, төсөвт магадлал хийх, шүүмж дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах, салбарын сургалтын хөтөлбөр, мэргэшлийн зэргийн аттестатчиллыг хэрэгжүүлэх, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, дулаанжуулалтын болон цахилгаан тоноглолд хяналт шинжилгээ хийх, сэргээгдэх эрчим хүчний зураг төсөл боловсруулах, энэ чиглэлээр хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төсөл боловсруулах, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж туршин нэвтрүүлэх, зохион бүтээх, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэдгээртэй холбоотой судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, засвар үйлчилгээ үзүүлэх, нарны зайн үйлдвэрлэл, угсралт, тохируулга хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хуулийн этгээд мөн.

1.3.“Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “компани” гэх) нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр болон энэ дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.4.Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, арилжааны банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, санхүүгийн тайлан гаргадаг, ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

1.5.“Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани нь 100 хувь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани бөгөөд Засгийн газраас эрх олгосны нийт хувьцааны 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмшиж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлнэ.

Хоёр.Компанийн оноосон нэр, байршил

2.1.Компанийн оноосон нэр нь монголоор “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, товчилсон нэр нь “ЭХҮТ”

ТӨХХК, англиар “National Energy Center” limited liability company, товчилсон нэр нь “NEC” LLC болно.

2.2.Компанийн байршил нь түүний гүйцэтгэх удирдлагын байрлаж буй хаягаар тодорхойлогдох бөгөөд хаягийн өөрчлөлтийг компанийн гүйцэтгэх удирдлага тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.

Гурав.Компанийн бэлгэдэл, тэмдэг

3.1.Компани нь өөрийн нэр бүхий тэмдэг, бэлгэдэл (эмблем)-тэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэж болно.

3.2.Тэмдэг, бэлгэдлийн загварыг төлөөлөн удирдах зөвлөлөөс баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн компани эдэлнэ.

3.3.Компанийн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг гүйцэтгэх удирдлагаас итгэмжлэн хариуцуулсан этгээд хадгална.

Дөрөв.Компанийн үндсэн зорилго, үйл ажиллагааны чиглэл, хугацаа

4.1.Компанийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь энэ дүрмийн 1.2-т заасан чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэхэд оршино.

4.2.Компани нь үндсэн зорилтын хүрээнд дараахь чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

4.2.1.эрчим хүчний салбарт улсын төсөв болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд захиалагчийн үүрэг гүйцэтгэж, техникийн хяналт тавих;

4.2.2.эрчим хүчний барилга байгууламжийг барих, зөвлөх үйлчилгээний ажлын зураг төсөвт магадлал, шүүмж, дүгнэлт хийх, эдгээртэй холбоотой ажлыг зохион байгуулах;

4.2.3.салбарын хэмжээнд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, ажлыг зохион байгуулах, мэргэшлийн зэргийг аттестатчилах арга хэмжээг зохион байгуулах;

4.2.4.цахилгаан болон дулаанжуулалтын тоноглолын найдвартай байдлыг хангах зорилгоор түлш, уур-ус, тос, металл судлал, гагнуурын хяналт шинжилгээ хийх, техникийн дүгнэлт гаргах;

4.2.5.эрчим хүчний шинэ эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, зуух, даралтад сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход урьдчилсан дүгнэлт, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулах;

4.2.6.эрхэлсэн асуудлаараа хууль тогтоомжийн хүрээнд гадаад, дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, гэрээ хэлэлцээр байгуулах, мэдээлэл солилцох;

4.2.7.компани техник хяналт тавигдсан эрчим хүчний барилга байгууламжийн техникийн хяналт, зураг төсөв, холбогдох материалаар мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, сонирхогч байгууллага, иргэдэд энэ талын мэдээллээр хангах;

4.2.8.компанийн үндсэн болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх.

4.3.Компани нь тодорхой мэргэшил шаардахаар үйл ажиллагаа явуулахдаа холбогдох эрх бүхий байгууллагаас зохих тусгай зөвшөөрөл авна.

4.4.Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

4.5.Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагааг Иргэний хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулна.

Тав.Компанийн өөрийн хөрөнгө, хувьцаа

5.1.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 100 (зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200 (хоёр зуун) ширхэг энгийн хувьцаатай байна. Хувьцааны 70 хувийг буюу 140 (нэг зуун дөр) ширхэг хувьцааг Эрчим хүчний яам, 30 хувийг буюу 60 (жаран) ширхэг хувьцааг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмшинэ. Хувьцааны хэмжээнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг гагцхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

5.2.Компанийн хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

5.3.Компанийн хөрөнгө нь 100 хувь төрийн өмчид байгааг харгалзан компанийн хувьцаа нь хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гарах хүртэл арилжаалагдахгүй байна.

5.4.Ногдол ашиг хуваарилах асуудлыг Компанийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Зургаа.Компанийн удирдлага

6.1.Компанийн удирдлага нь дараахь бүтэцтэй байна:

6.1.1.хувьцаа эзэмшигчдийн хурал;

6.1.2.төлөөлөн удирдах зөвлөл;

6.1.3.гүйцэтгэх удирдлага.

Долоо.Хувьцаа эзэмшигчдийн хурал

7.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит, ээлжит бус байна.

7.2.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш 4 (дөрөв) сарын дотор зарлан хуралдуулна.

7.3.Шаардлагатай гэж үзвэл хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу зарлан хуралдуулж болно.

7.4.Дараахь асуудлыг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

7.4.1.компанийн дүрэмд өөрчлөлт оруулах буюу шинэчилсэн найруулгыг батлах;

7.4.2.нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон тусгаарлах хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

7.4.3.компанийн хэлбэрийг өөрчлөх;

7.4.4.компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

7.4.5.компанийн зорилтот түвшинг батлах;

7.4.6.компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

7.4.7.компанийн их хэмжээний хэлцлийг батлах;

7.4.8.төлөөлөн удирдах зөвлөлийн жилийн ажлын тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;

7.4.9.компанийн сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

7.4.10.төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудал.

7.5.Хувьцаа эзэмшигч нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо зөвхөн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлсэн этгээдийн хүрээнд хэлэлцэн шийдвэр гаргана. Хэрэв нэр дэвшүүлсэн этгээдийг шаардлага хангахгүй гэж үзвэл дахин нэр дэвшүүлэх тухай шийдвэр гаргана.

7.6.Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол, хурлын тэмдэглэл гаргана. Хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө.

Найм.Төлөөлөн удирдах зөвлөл

8.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгож, чөлөөлнө.

8.2.Төлөөлөн удирдах зөвлөл 9 (ес) гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

8.3.Төлөөлөн удирдах зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.3.1.компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тогтоох;

8.3.2.хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан зорилтот түвшинг үндэслэн компанийн бизнес төлөвлөгөөг батлах;

8.3.3.компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах;

8.3.4.хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

8.3.5.компанийн гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг түдгэлзүүлэх;

8.3.6.компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах хөлсөөр ажиллах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, үүрэг хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах;

8.3.7.компанийн хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, компанийн тайлан, тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

8.3.8.компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

8.3.9.компаниас хуваарилах ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журам, хугацааг тодорхойлох;

8.3.10.төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;

8.3.11.компанийн шинээр худалдаж авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

8.3.12.компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах;

8.3.13.хууль тогтоомжийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

8.3.14.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ажлыг дүгнэх;

8.3.15.хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй бусад асуудлыг шийдвэрлэх.

8.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал нийт гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хүчин төгөлдөр болно.

8.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно.

8.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүргийг хүлээнэ.

8.7.Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тогтоол, тэмдэглэлд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдгийг дарснаар хүчин төгөлдөр болно.

8.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн томилсон гишүүн гүйцэтгэнэ.

8.9.Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно.

8.10.Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нь хуралд оролцож байгаа гишүүдийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно.

8.11.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарах шийдвэрийн талаар хуралд оролцсон гишүүд санал тэнцвэл төлөөлөн удирдах зөвлөлийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

8.12.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зарлах, хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудлыг хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эрх болон бусад холбогдох асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна. Энэ журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

8.13.Хараат бус гишүүн нь компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан этгээд байна:

8.13.1.өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй;

8.13.2.өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй;

8.13.3.төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй;

8.13.4.компанитай төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад байдлаар бизнесийн аливаа холбоогүй.

8.14.Хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараахь нэмэлт үүрэгтэй:

8.14.1.төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих,

зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;

8.14.2.компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

8.14.3.хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх;

8.14.4.төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт хийх талаар санал боловсруулах;

8.14.5.гүйцэтгэх удирдлагын бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулахад хяналт тавих бөгөөд хороод нь уг хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, хууль тогтоомжид нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох журмыг мөрдлөг болгон ажиллах.

8.15.Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилно. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хуулийн дагуу ажиллах бөгөөд шаардлагатай бол нэмэлт үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгаж болно.

8.16.Төлөөлөн удирдах зөвлөл нь жилд нэгээс доошгүй удаа хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана.

Ес.Гүйцэтгэх удирдлага

9.1.Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь хувь хүн байх бөгөөд компанийн гүйцэтгэх захирал байна.

9.2.Гүйцэтгэх захирлыг төлөөлөн удирдах зөвлөл холбогдох хууль, журамд заасны дагуу томилж, чөлөөлнө.

9.3.Гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурна. Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

9.4.Гүйцэтгэх захирал нь өөрт олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

9.5.Гүйцэтгэх захирал нь компанийн ерөнхий инженер, ерөнхий нягтлан бодогч нарыг томилох, чөлөөлөх асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөнө.

9.6.Гүйцэтгэх захирал нь дараахь шалгуурыг хангасан байна.

9.6.1.менежментийн ур чадвартай, 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажил гүйцэтгэж байсан, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, удирдлагын зохих дадлага туршлагатай, эрчим хүчний инженер, эсхүл санхүү, эдийн засгийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх;

9.6.2.зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

9.6.3.ял шийтгэлгүй байх;

9.6.4.ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

9.7.Өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагааны талаар гүйцэтгэх захиралд зөвлөх эрх бүхий захирлын зөвлөл ажиллана. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

9.8.Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбогдож үүссэн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийг төлөөлөн оролцоно.

9.9.Гүйцэтгэх захирал дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

9.9.1.төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд хоёроос доошгүй удаа ажлын үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;

9.9.2.компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

9.9.3.компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан батлуулах;

9.9.4.энэ дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм, норматив компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

9.9.5.гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

9.9.6.компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийг удирдах;

9.9.7.гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх;

9.9.8.төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;

9.9.9.компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

9.9.10.компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

9.9.11.мэргэжлийн хүний нөөц бэлтгэх, давтан сургах;

9.9.12.төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлийн дагуу зарим эрх, үүргээ итгэмжлэлийн үндсэн дээр компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Арав.Компанийн эрх бүхий албан тушаалтан

10.1.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ерөнхий инженер, ерөнхий нягтлан бодогч, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

10.2.Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль, энэ дүрэм, төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

10.3.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, түүний хэмжээг тогтоох асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан онцгой нөхцөл бүхий гэрээ, компанийн хөдөлмөрийн дотоод журмаар тогтоох бөгөөд тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

10.4.Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуульд зааснаар үүрэг,хариуцлага хүлээнэ.

Арван нэг.Компанийн хяналтын тогтолцоо

11.1.Компанийн хяналтын тогтолцоо нь дараахь бүтэцтэй байна:

11.1.1.өмчлөгчийн хяналт;

11.1.2.дотоод хяналт;

11.1.3.хөндлөнгийн аудит.

11.2.Өмчлөгчийн хяналтыг төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо хэрэгжүүлнэ. Аудитын хороо 3 гишүүнтэй байх бөгөөд гишүүдийг төлөөлөн удирдах зөвлөл томилно.

11.3.Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.

11.4.Компанийн аудитын хорооны ажиллах журмыг төлөөлөн удирдах зөвлөл дотоод хяналтын ажиллах журмыг компанийн гүйцэтгэх удирдлага тус тус батална.

11.5.Аудитын хороо нь дараахь чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

11.5.1.компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэх, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

11.5.2.аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;

11.5.3.их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт гаргах;

11.5.4.компанийн дотоод хяналтын аудиторыг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;

11.5.5.компанийн дүрэмд заасан болон төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

11.6.Аудитын хороо нь компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган, үйл ажиллагаагаа хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

11.7.Аудитын хороо нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгахдаа энэ дүрэм болон холбогдох хуулиар олгогдсон эрхийг эдэлнэ.

11.8.Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод аудитор хэрэгжүүлнэ.

11.9.Дотоод хянан шалгагч нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж, гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, энэ дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолд нийцэж байгаа эсэхийг хангаж ажиллана.

11.10.Дотоод хянан шалгагч нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад өгөх, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, мэдээлэх үүрэгтэй.

11.11.Компанийн хөндлөнгийн аудитыг төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгосон мэргэшсэн аудитын байгууллагаар хийлгэнэ.

11.12.Хөндлөнгийн аудитын тайланг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

Арван хоёр.Их хэмжээний болон сонирхлын
зөрчилтэй хэлцэл

12.1.Их хэмжээний хэлцэл гэж тухайн хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийнэ.

12.2.Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийнэ.

12.3.Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн энэ дүрмийн 12.1, 12.2-т заасан хэлцлийн талаарх мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Арван гурав.Компанийн нягтлан бодох
бүртгэл, тайлан

13.1.Компани нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал хариуцна.

13.2.Компанийн ахлах нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх бөгөөд түүнийг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн гүйцэтгэх захирал томилж, чөлөөлнө.

13.3.Компани нь хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулсны дараа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу жилийн санхүүгийн тайлан, ашиг ба алдагдлын тайлангаа компанийн хувьцаа эзэмшигчид болон холбогдох хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээдэд танилцуулна.

13.4.Компанийн санхүүгийн жилийн эхлэх хугацаа тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдөр, дуусах хугацаа мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр байна.

Арван дөрөв.Компанийн санхүүгийн болон
үйл ажиллагааны тайлан

14.1.Компани Нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.

14.2.Компанийн санхүүгийн тайланд дараахь зүйлийг тусгана.

14.2.1.баланс;

14.2.2.үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;

14.2.3.мөнгөн гүйлгээний тайлан;

14.2.4.өмчийн өөрчлөлтийн тайлан;

14.2.5.хуримтлагдсан ашгийн тайлан;

14.2.6.тухайн тайлангийн хугацаанд байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр, төрөл, үнийн дүнгийн хамт;

14.2.7.эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин, урамшууллын дүн, албан тушаалтан бүрийн нэрээр гаргах;

14.2.8.нэмэлт тайлбар, тодруулга;

14.2.9.санхүүгийн тайлангийн тодруулга;

14.2.10.хуульд заасан бусад.

14.3.Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

Арван тав.Компанийн баримт бичиг хадгалах

15.1.Компани нь дараахь баримт бичгийг хадгалах үүрэгтэй:

15.1.1.компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, түүний шинэчилсэн найруулга, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл;

15.1.2.хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлаас баталсан компанийн дотоод баримт бичиг;

15.1.3.нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг;

15.1.4.хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, компанийн гүйцэтгэх захирлын тушаал, байгуулсан гэрээ түүний биелэлттэй холбогдох баримт бичиг;

15.1.5.аудитын дүгнэлт;

15.1.6.санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;

15.1.7.анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг;

15.1.8.эрх бүхий албан тушаалтан болон нийт ажилчдад олгосон цалин, шагнал, урамшуулалтай холбоотой баримт бичиг;

15.1.9.компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт, тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо;

15.1.10.бусад баримт бичгүүд.

15.2.Компани нь баримт бичгийг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газарт хадгална.

15.3.Компани нь өөрийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг байнга хадгална. Бусад баримт бичгийг 5 жилийн хугацаатайгаар хадгалах бөгөөд хугацаа дууссаны дараа архивд шилжүүлнэ.

15.4.Хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, компанийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлттэй холбогдол бүхий баримт бичгийг хүлээн авах, хадгалах, танилцуулах, архивд шилжүүлэх ажиллагааг төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг биечлэн хариуцна.

15.5.Компанийн талаарх мэдээлэл, компанийн нэгдмэл сонирхолтой этгээд түүнтэй холбогдох мэдээлэл авах асуудлыг Компанийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

Арван зургаа.Компанийг татан буулгах

16.1.Компанийг Иргэний хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу Засгийн газрын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана.

16.2. Татан буулгах комисс томилогдсоноор компанийн гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

Арван долоо.Бусад

17.1.Энэ дүрмээр зохицуулагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

17.2.Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга нь улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болно.

17.3.Энэ дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газар шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь энэ дүрмийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн уг дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

Засгийн газрын 2022 оны 318 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ” АЖ АХУЙН ТООЦООТОЙ ТӨРИЙН ӨМЧИТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРААС “ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН
ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ҮЛ ХӨДЛӨХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Анхны үнэ, (мян,төг)	Хуримтлагдсан элэгдэл (мян,төг)	Үлдэгдэл өртөг (мян,төг)	Бодит үнэ (мян,төг)
1.	Газар №1	4,433.0	м.кв				539,052.8
2.	Газар №2	4,193.0	м.кв				401,437.8
3.	Газар №3	16,796.0	м.кв				1,612,416.0
4.	Газар №4	1,149.0	м.кв				110,005.3
5.	Газар №5	41,920.0	м.кв				3,756,032.0
6.	Газар №6	5,922.0	м.кв				720,115.2
7.	Газар №7	330,000.0	м.кв				5,745,300.0
8.	ЭХХТ-ийн конторын барилга	1,451.1	м.кв	2,091,275	159,496.06	1,931,778.55	1,757,087.7
9.	ЭХХТ-ийн конторын барилгын өргөтгөл	915.1	м.кв			-	711,311.7
10.	Сургалт, үйлдвэрлэлийн цогцолборын барилга	2,008.0	м.кв	1,481,241.57	782,753.68	698,487.90	1,024,058.2
11.	ЭХХТ-ийн залгаа авто гараж “Б” блок	750.8	м.кв	261,151.44	154,315.46	106,835.98	196,664.5
12.	ЭХХТ-ийн хашаанд авто гараж	149.0	м.кв	98,561.60	71,189.85	27,371.75	20,255.4
13.	Техник үйлчилгээний байр	558.4	м.кв	68,250.00	43,609.45	24,640.55	132,325.2
14.	Сэлбэгийн агуулах	529.9	м.кв	34,020.00	21,737.63	12,282.37	74,720.1
15.	Авто гараж (дулаан зогсоол)	18.0	м.кв	25,000.00	1,900.52	23,099.48	12,091.2
16.	СҮЦ-ийн хашаанд байгаа авто гараж (3 машины)	52.8	м.кв	3,694.95	1,130.54	2,564.41	7,040.1
17.	Ацетлин кислородны агуулах	26.5	м.кв	3,150.84	912.14	2,238.70	2,386.1
18.	СҮЦ-ийн барилгад залгаа Автомашины гараж	21.5	м.кв	1,500.00	1,500.00	-	1,734.5
19.	Гадна дулааны шугам	92.0	метр	66,972.0	9,885.50	57,086.5	76,964.4
	Нийт дүн			4,134,817.0	1,248,430.8	2,886,386.18	16,900,998.20

Засгийн газрын 2022 оны 318 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

“СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРААС ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД БАЛАНСААС
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Анхны үнэ, (мян,төг)	Хуримтлагдсан элэгдэл (мян,төг)	Үлдэгдэл өртөг (мян,төг)	Бодит үнэ (мян,төг)
1.	Газар	12430.7	м.кв	0	0	0	73,092,516.00
2.	Оффисын барилга	825.09	м.кв	228,096,160.09	131,553,834.76	96.542,325.33	497,466,505.52
3.	Механик засварын цех, агуулах, гараж, дулааны узельтэй барилга	902.59	м.кв	249,521,032,58	143,910,574.26	105,610,458.32	513,976,677.01
4.	Үйлдвэр, гаражтай барилга	538.12	м.кв	148,763,290,14	85,798,821.42	62,964,468.73	203,695,939,10
5.	Агуулахын барилга	443.6	м.кв	122,633,233.31	70,728,382,48	51,904,850.83	170,002,686.37
6.	Туршилтын байр	22.85	м.кв	6.316,883.19	3,643,232.00	2,673,651.19	2,124,671.55
7.	Харуулын байр	13.18	м.кв	1,518,000.00	1,518,000.00		1,231,543.69
8.	Дулааны шугам	256.5	м	22,000,000.00	22,000,000.00		58,420,440.00
9.	Бохирын шугам	330	м	300,000.00	300,000.00		64,638,000.00
	Нийт дүн			779,148,559.31	459,452,844.92	319,695,754.39	1.584,648,979.24

---o0o---